



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 696

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлага худалдааны талаар авах арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дугаар тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй нийт 160,627,000.00 (нэг зуун жаран сая зургаан зуун хорин долоон мянга) төгрөгийн 11 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт, харьяа байгууллагуудын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1 Үндсэн хөрөнгийг дуудлагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2 Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг батлагдсан маягтын дагуу гарган 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001295



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны
12 дугаар сарын 28-ны өдрийн 68 дугаар тогтоолын
хавсралт

Гаалийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тээврийн хэрэгсэл

д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуриятлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэх өртөг /төгрөг/	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/	Эзэмшигч байгууллага
1	УАЗ-315122 маркийн 81-42 ДОА улсын дугаартай, суудлын автомашин Арлын дугаар -80510204	2008/2008	86392	14,000,000.00	14,000,000.00	0.00		500,000.00	Дорнод аймаг дахь Гаалийн газар
2	УАЗ-315192 маркийн 14-48 ДОР улсын дугаартай, суудлын автомашин Арлын дугаар -315100B0589956	2011/2011	52460	20,700,000.00	20,700,000.00	0.00		500,000.00	Дорнод аймаг дахь Гаалийн газар
3	УАЗ-315192 маркийн 14-17 ДОР улсын дугаартай, суудлын автомашин Арлын дугаар -315100B0588818	2011/2011	75503	21,000,000.00	21,000,000.00	0.00		500,000.00	Дорнод аймаг дахь Гаалийн газар
4	Трактор Эрэнцав	2007/2007		1,968,000.00	1,968,000.00	0.00		100,000.00	Дорнод аймаг дахь Гаалийн газар
5	УАЗ-31519 маркийн 32-06 ДОА улсын дугаартай, суудлын автомашин Арлын дугаар -A0548409	2011/2011	97148	23,000,000.00	23,000,000.00	0.00		500,000.00	Дорнод аймаг дахь Гаалийн газар
6	Хьюандай старекс маркийн 04-58 УБА улсын дугаартай, микроавтобус, арлын дугаар- 728452	2006/2013	168393	18,000,000.00	18,000,000.00	0.00		1,500,000.00	Дорнод аймаг дахь Гаалийн газар
7	Делика -Мицубуши маркийн, 20-34УБӨ улсын дугаартай, микроавтобус, арлын дугаар-PD6W0500389	1999/2007	179549	12,859,000.00	12,859,000.00	0.00		1,000,000.00	Дорнод аймаг дахь Гаалийн газар

8	УАЗ-31519 маркийн 55-05 УБА улсын дугаартай, суудлын автомашин Арлын дугаар -315100В0586820	2011/2011	91234	21,000,000.00	21,000,000.00	0.00	500,000.00	Увс аймаг дахь Гаалийн газар
10	Истана маркийн 25-05 ДАР улсын дугаартай, суудлын автомашин Арлын дугаар -KPDFBDL811P125932	2001/2007	199797	12,800,000.00	12,800,000.00	0.00	1,000,000.00	Дархан аймаг дахь Гаалийн газар
11	УАЗ-22000-030 фургон 70-32 ГАА Арлын дугаар- 80467640	2007/2007	114681	15,300,000.00	15,300,000.00	0.00	500,000.00	Говь-Алтай гаалийн хороо
				160,627,000.00	160,627,000.00	0.00	6,600,000.00	
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН			160,627,000.00 (нэг зуун жаран сая зургаан зуун хорин долоон мянга)	160,627,000.00 (нэг зуун жаран сая зургаан зуун хорин долоон мянга)		6,600,000.00 (зургаан сая зургаан зуун мянга)	